



КРЕДИТ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ББСБ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 7 дугаар сарын 17-ны өдөр

Дугаар 2020/22

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн  
хараат бус гишүүнийг чөлөөлөх,  
түр гишүүн томилох тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.5 дахь хэсэг, Ард Кредит ББСБ ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Б.Чулуунбаатар өөрийн хүсэлтээр үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлт ирүүлснийг хүлээн авч үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Б.Чулуунбаатар чөлөөлөгдсөнтэй холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх дуусах хүртэл хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөлийн түр гишүүнээр Ч.Чинзоригтыг томилсугай.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн түр гишүүн томилогдсонтой холбогдуулан түр гишүүний материалыг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хүргүүлэх, Монголын хөрөнгийн биржийн сайтаар нийтэд мэдээлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (М.Мөнхсүрэн)-д үүрэг болгосугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороонд үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ГАНХУЯГ